



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2021 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 53

Мандалговь

**Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Дэлгэрцогт сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 35,000,000 /гучин таван таван сая/ төгрөгийн анхны өртөгтэй, 5,800,000 /таван сая найман зуун мянга/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 29,700,000 /хорин есөн сая долоон зуун мянга/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй ДУА 38-59 улсын дугаартай УАЗ-315195-066 маркийн автомашиныг тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Дэлгэрцогт сумын Эрүүл мэндийн дарга (С.Батцэцэг), Дэлгэрцогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга П.Түвшинсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын
30-ны өдрийн 53 дугаар тогтоолын хавсралт

Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газрын тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Сери	Дугаар			Арлын дугаар	Моторын н дугаар	Моторын эзлэхүүн /см3/				
1	Суудал	УАЗ 315195- 066	ДУА	38-59	2014	2014.08.05	315100E0591 087	409050E 3023121	В. 2693	114,127	35,000,000	5,800,000	29,700,000